

БАТЛАВ:

УУЯ-НЫ ХШУДАГ-ЫН ДАРГА БӨГӨӨД
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

Д.ЖАВХЛАНБОЛД

ГЕОЛОГИЧДЫН АЖИЛ МЭРГЭЖЛИЙН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ НАРИЙВЧИЛСАН УДИРДАМЖ

Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 5 дугаар сарын 12-ны өдийн 67 дугаар тушаалаар батлагдсан геологичдын ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулах бүрэлдэхүүн, удирдамж батлагдсан.

Зорилго: Геологийн салбарын хүний нөөцийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, геологийн судалгааны ажилд гарч буй шинэлэг арга, аргачлал, техник технологи, ажлын туршлага зэргийг харилцан солилцож, салбарын тэргүүний ажилтан, аж ахуйн нэгжийг шалгаруулан, олон нийтэд үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилготой.

Нэг. Бэлтгэл ажил

1. Ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулах
2. Зохион байгуулах газар болон хугацааг товлох
3. Аж ахуйн нэгжид зарлан мэдээлэх, УУЯ, АМГ-ын вэб сайтад мэдээлэл бэлтгэн, зар гаргах, зар дээр тэмцээн болох байрлалын зураг, координатыг тавих
4. Ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулах болон зохион байгуулах комиссын ажлын зардлыг тооцох, батлуулах
5. Ажил мэргэжлийн уралдаан болох Баянхонгор аймгийн Засаг дарга, Шинэжинст сумын Засаг даргад УУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын албан бичгийг хүргүүлэх
6. Оролцогчдыг бүртгэх, такс хураах, таксын төлбөрийг Монголын Геологийн Холбооны дансаар хүлээн авах
7. Уралдааны үеэр хэрэглэх байр зүйн зураг, агаар сансрын зураг бэлтгэх
8. Талбайн талаар товч танилцуулга, мэдээлэл бэлтгэх, Шинэжинст сумаас уралдаан болох газар хүртэл замын тэмдэг, тэмдэглэгээ бэлтгэх, байршуулах
9. Уралдаанд оролцогчдын байрлах кэмгийн байршлын гортиг татах, авто зогсоол бэлтгэх, бие засах газар байгуулах, ариун цэврийн халваргүйтэл хийх
10. Усны нөөц болон худаг насос бэлтгэх
11. Комисс, шүүгчдийн ажиллах гэр 2, майхан, асар бэлдэж, ширээ, сандал, бичгийн хэрэгсэл бэлдэх, аюулгүй ажиллагааг хангах
12. Спортын тэмцээний талбай бэлтгэх /Гар бөмбөгийн талбай, тор, бөх барилдах талбай, шатрын тэмцээний бэлтгэл хангах
13. Комиссын гишүүд, шүүгчдийн хоол хүнсийг бэлтгэх, комиссын гишүүд, шүүгчдийн очих, буцах, тэмцээний үеэр хэрэглэх машин, бензин тосыг зохицуулах
14. Уралдаанд оролцогчдын хувийн бэлтгэл хангуулах арга хэмжээ авах, энэ талаар мэдээлэх, гэр майхан, хоол хүнс, ундны ус, геологийн алх, луп, компас, GPS болон бусад багаж, хэрэгслийг бэлдүүлэх
15. Уралдаан тэмцээнд оролцох компаниудын бүртгэлийг нэгтгэж, мэдээлэх

Хоёр. Уралдааныг зохион байгуулах

1. Уралдаан тэмцээнд оролцох багууд болон ажлын хэсгийн гишүүд бусад хүмүүс Баянхонгор аймгийн Шинэжинст суманд очих, бүртгэлийг дахин шалгах, нэгдсэн зохион байгуулалтаар уралдаан болох кэмп рүү хөдлөх
2. Уралдаан болох газарт бүх геологичдыг байрлуулах, нэгдсэн зохион байгуулалтад оруулах
3. Уралдаанд оролцогч багуудын материалыг хүлээн авч, битүүмжлэн, шүүгчдэд хүлээлгэн өгөх
4. Уралдааныг шүүх шүүгчдийг томилох, батлах
5. Геологийн ажил мэргэжлийн уралдааны албан ёсны нээлтийг хийж, тэмцээнийг эхлүүлэх
6. 1:50 000-ны зураглалын уралдааныг эхлүүлэх, оролцогч багуудыг маршрутанд явуулах, хяналт хийх
7. Ерөнхий эрлийн ажлын уралдааныг оролцогч багуудыг маршрутанд явуулах, хяналт хийх
8. Геофизикийн ажлын уралдааныг эхлүүлэх, оролцогч багуудыг хэмжилтэд гаргах
9. 1:50 000-ны зураглал, ерөнхий эрлийн уралдаанд оролцох багуудын оролцогч нар маршрутад явахдаа авсан онцлох болон ховор дээжүүдийг геологичдод үзүүлэн таниулах
10. Геологичдын дунд үндэсний бөхийн барилдааны тэмцээн явуулах
11. Гар бөмбөгийн тэмцээн явуулах
12. Шатрын тэмцээн явуулах
13. Уралдааны үеэр геологийн хээрийн сургалт, харилцан дадлага туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулах
14. Уралдааны үеэр хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, кэмпиин дотоод дэг журмыг мөрдүүлэх
15. Уралдааны үеэр оролцогчдын үйл ажиллагаанд хяналт тавих, төөрөх, осолдох, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх

Гурав. Уралдааныг дүгнэх

1. 1:50000-ны зураглалын уралдааныг дүгнэх, 1,2,3-р байранд шалгарсан багуудын шагналыг гардуулах
2. Ерөнхий эрлийн ажлын уралдааныг дүгнэх, 1,2,3-р байранд шалгарсан багуудын шагналыг гардуулах
3. Геофизикийн ажлын уралдааныг дүгнэх, 1,2,3-р байранд шалгарсан багуудын шагналыг гардуулах
4. Онцлох болон ховор дээжүүдийг шалгаруулж, шагналыг гардуулах
5. Үндэсний бөхийн барилдаанд түрүүлсэн, үзүүрлэсэн бөхийн бай шагналыг гардуулах
6. Гар бөмбөгийн тэмцээний 1,2,3-р байрын шагналыг гардуулах
7. Шатрын тэмцээний 1,2,3-р байрын шагналыг гардуулах
8. Тэмцээнийг дүгнэж, комиссын дарга үг хэлэх

Дөрөв. Уралдааныг сурталчлах

1. Уралдаан тэмцээнийг сурталчлах ажлыг зохион байгуулах, ТВ радио, сонин сэтгүүлд ярилцлага өгөх, хөрөг нэвтрүүлэг хийлгэх, уралдаан тэмцээний бичлэг хийх, олон нийтийн ТВ-ээр мэдээ явуулах ажлыг зохион байгуулах.